

## ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

*2013 оны 10 дугаар сард төрийн бус байгууллагын төлөөлөгчид, бие даасан судлаачид Захиргааны ерөнхий хуулийн төслийг хэлэлцлээ. Оролцогчид хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулах харилцааг бүрэн дүүрэн дэмжсэнийг тэмдэглээд хэлэлцүүлгийн явцад гарсан хуулийн төслийн нэр томъёо, зүйл заалтын логик дэс дараалал, төслийн эх бичвэр, техник шаардлага, утга найруулгын холбогдолтой санал шүүмжийг<sup>1</sup> нэгтгэн танилцуулж байна.*

- ☑ Захиргааны ерөнхий хуулийн төсөл (Хуулийн төсөл гэх)-ийн зарим зүйл, заалт, хэсэг нь тодорхой нэг агуулгаар ойлгогдохгүй байгаа нь хуулийн төсөлд тавигддаг «зүйл нь хоорондоо уялдаа холбоо, дэс дараалал бүхий, агуулгыг нь товч илэрхийлсэн гарчигтай байна», «зүйл, заалт, хэсэг нь хоорондоо зөрчилгүй байх» зэрэг нийтлэг шаардлагыг<sup>2</sup> хангахгүй байна.

Хуулийн төслийн 77 дугаар зүйлийн гарчиг нь «төлөвлөлтийн ажиллагаа хийхгүй байх» гэсэн боловч зохицуулсан харилцаа нь төлөвлөлтийн ажиллагаа хийх явцад «санал авах, сонсох ажиллагааг хийхгүй байх» тухай өөр харилцааг зохицуулжээ. Түүнчлэн төлөвлөлт, төлөвлөгөө гэсэн хоёр өөр үгийг нэг утга, агуулгаар олон дахин хэрэглэсэн, хуулийн төслийн 92, 98 дугаар зүйлд заасан харилцааг нэг зүйлийн доторх хэд хэдэн хэм хэмжээгээр нэгтгэн зохицуулах боломжтой байхад зүйл тус бүрт «Албадлага хэрэглэх», «Албадлагыг хэрэглэх» гэсэн нэг агуулгатай нэр өгч, ялгамжтай байдлаар зохицуулжээ.

Хуулийн төслийн Наймдугаар бүлгийн 83, 86 дугаар зүйлийн доторх заалтууд өөр өөр харилцааг зохицуулсан мэт боловч «Төлбөрийн шийдвэр гүйцэтгэл» гэсэн нэг ижил гарчиг өгсөн. Мөн уг бүлэгт захиргааны шийдвэр гүйцэтгэл, төлбөрийн шийдвэр гүйцэтгэл гэх ялгаатай ойлголтууд байх боловч тухайн зүйл, заалтаар зохицуулсан харилцаа нь ижил утга, агуулгатай байгаа зэрэг зөрчил байна. Түүнчлэн төлбөр төлөгч, төлбөрийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, төлбөрийн шийдвэр гүйцэтгэх журам зэрэг зүйлүүдэд заасан хэм хэмжээгээр хэн, хэний шийдвэрийг ямар тохиолдолд, хэрхэн яаж биелүүлэх нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, энэ бүлгээр захиргааны шийдвэрийг хэрхэн яаж гүйцэтгэх, холбогдох этгээд захиргааны шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх тухай харилцааг бус харин зөвхөн төлбөр төлөгч, төлбөр авагч субъектуудын харилцааг зохицуулсан мэт болжээ.

**Санал:** Хуулийн төслийн эх бичвэрийг «мэргэжлийн түвшинд хангалттай сайн боловсруулах».<sup>3</sup>

<sup>1</sup> Хэлэлцүүлгээс гарсан дэлгэрэнгүй саналыг [www.fogim.mn](http://www.fogim.mn) цахим хуудаснаас үзэх боломжтой.

<sup>2</sup> Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 17-р зүйлийн 17.2.1-т заасан.

<sup>3</sup> Мөн хуулийн 2.1.3-т заасан.

- ☑ Хуулийн төслийг Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.5-д заасан «үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих» шаардлагад бүрэн дүүрэн нийцүүлэх шаардлагатай байна.

**Санал:** Энэ хүрээнд хуулийн төслийн 2.1.5, 2.1.6, 9, 11, 19, 20.1, 29.1.1, 35.1, 37.1, 37.2, 37.4, 40.2.4, 40.5.2, 43.10, 55.2, 56.4, 60.1.9, 60.1.11, 72.1, 72.1.6, 74.1, 81.1, 81.2, 95.1, 101.4, 102.3, 110.1, 110.2, 111.1, 112.4 заалтын найруулга, үг хэллэгийг засаж сайжруулах нь зүйтэй. Хэлэлцүүлэгт оролцогчид өөрсдийн хувилбарыг боловсруулсан бөгөөд энэ тухай мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хаягаар орж үзэх боломжтой. Мөн утга найруулга нь ойлгомжгүй байгаа 3.2, 37.3, 41.1.4, 49.3.3, 49.3.4, 51.1, 55.1.11, 72.3, 72.4, 73.3, 74.1, 75.3, 78.1, 80.1, 95.2, 96.1, 102.1.3, 102.5, 113.1 заалтыг шинээр найруулах шаардлагатай гэж үзлээ.

- ☑ Хуулийн төслийн зарим зүйл, заалт тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, «төлөвлөлтийн эрх зүйн үйлчлэл» (78) гэж юу болох, «... энэ журам үйлчилнэ» (82.1) ямар журам, «овог» (102.4.1, 102.4.3) гэж ургийн овгийг хэлж байгаа юу зэргийг дурдаж болно. Мөн хуулийн төслийн 50-р зүйлийн 50.1-д заасан «Захиргааны актын хөөн хэлэлцэх хугацаа», 106-р зүйлийн 106.1.2 «маргаан бүхий захиргааны шийдвэр...» гэсэн ойлголтыг тайлбарлаагүй тул тодорхойгүй байдлыг үүсгэхээр байна. Түүнчлэн 91-р зүйлийн 91.1-д «албадлагыг хуулинд зааснаар даруй хэрэглэхээс...» гэсэн нь ямар хуулинд заасан гэдгийг мэдэх боломжгүй тул тодорхойгүй заалт болжээ.
- ☑ Зарим зүйлийн агуулга, утга санаа давхцах, эсхүл бусад хууль тогтоомж, хуулийн төслийн зүйл, заалттай зөрчилдөж байна.

**Санал:** Хуулийн төслийн 2.1.13, 14.2, 20.1.3, 20.1.4, 73.5, 96.2 заалтуудыг хасах, 4.1 болон 4.2, 60.1.2 болон 60.2.4 заалтыг хооронд нь нэгтгэх.

- ☑ Хуулийн төсөлд «бодит боломж», «бодит хэрэгцээ», «үр нөлөөтэй байх», «хууль ёсны итгэл», «адил нөхцөлд тэгш хандах» зэрэг нэр томъёоны утга агуулга ойлгомжгүй, ямар тохиолдолд хэрхэн тайлбарлаж хэрэглэх нь тодорхойгүй байна. Мөн ижил түвшний нэр томъёог хуулийн төслийн өөр өөр бүлэг, хэсэгт оруулан тайлбарлажээ. Тухайлбал, захиргааны шийдвэрийн нэг хэлбэр болох захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг нэр томъёоны хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан атал харин захиргааны акт, захиргааны гэрээг тухайн бүлэгт нь тайлбарласан байна.

**Санал:** Нэр томъёоны тайлбарыг Хууль, УИХ-ын шийдвэрийн төслийг өргөн мэдүүлэх журмын тухай хууль (цаашид Хуулийн хууль гэх)-ийн 13-р зүйлийн 13.4, 13.5-т нийцүүлэх.

- ☑ Үүний зэрэгцээ «даруй, ердийн боломжит хугацаа, боломжит хугацаа, шуурхай мэдэгдэнэ» гэсэн цаг заасан нэр томъёоны үр дагаврыг хэрхэн хэмжиж, дүгнэх нь тодорхойгүй байна. Мөн «их хэмжээний зардал, ноцтой хохирол, хамгийн бага хохирол» зэрэг нэр томъёог ч тодорхой томъёолох шаардлагатай байна (12.1.3, 12.4.2, 93.2).

**Санал:** «Ердийн боломжит хугацаа» гэсний оронд «24 цагийн дотор эсхүл 48 цагийн дотор» гэх зэргээр тодорхой болгох (2.1.13, 23.3, 88.2, 91.1, 97.1, 2.1.13, 24.2, 43.1).

- ☑ Хуулийн төсөлд хэрэглэсэн зарим нэр томъёог оновчтой нэрлээгүй, ижил агуулгатай байж болох зүйл дээр өөр өөр нэр томъёо хэрэглэжээ.

**Санал:** Тухайлбал «адил нөхцөлд тэгш хандах», «үр нөлөөтэй байх», «хууль ёсны итгэл», «шууд өртэй этгээд», «дамжуулах өртэй этгээд» (5.2.2, 5.2.5, 88.1.1, 84.1.2) гэсэн нэр томъёог нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр томъёогоор солих. «Хуулийг биелүүлэх» (1.1, 37.1, 40.3), «хуулийг хэрэгжүүлэх» (2.1.1), түүнчлэн «эрх зүйн хэм хэмжээ» (4.1, 4.4), «эрх зүйн акт» (4.3) гэсэн нэр томъёог өөр өөр утга агуулгаар хэрэглэсэн бол тайлбарлах, эсхүл аль нэгийг сонгож хэрэглэх.

- ☑ Хуулийн төслийн зарим нэр томъёо нь төөрөгдүүлэх, ойлгомжгүй байдлыг үүсгэх, эсхүл хүн амын зарим бүлгийн эрх ашгийг дордуулах утгаар хэрэглэгдэж болзошгүй байна. Тухайлбал, «олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл» (28.2.2, 43.6, 43.7, 43.9) гэдэг нь үндэсний олон нийтийн радио, телевиз мэт ойлгогдож байна. Мөн «ялимгүй эрх зүйн үр дагавар» (41.1.3), «нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх» (29.1.1), «гарцаагүй байдал» (29.1.2), «хойшлуулшгүй ажиллагаа» (9.2, 29.1.2) зэрэг нэр томъёог тайлбарлах шаардлагатай. Хуулийн төслийн 47.3.5-д заасан «Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан» хэмээх ойлголтын хүрээнд хүн амын тодорхой бүлгийг ялгаварласан, эрхийг хязгаарласан зан үйлийг оруулж болохоор байна.
- ☑ Хуулийн төслийн 5-р зүйлийн 5.2-т захиргааны үйл ажиллагааны зарчмуудыг тусгасан нь чухал ач холбогдолтой хэдий ч хуулийн бусад бүлэг, хэсэгт үүнийг хэрхэн мөрдөж ажиллахыг зохицуулаагүй нөхцөлд уг зарчим тунхаглалын шинжтэй болж болзошгүй. Тухайлбал 5.2.12-т заасан захиргааны үйл ажиллагаанд оролцогчдын хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим ойлгомжтой бус, бусад бүлэг, хэсэгт энэ зарчим сууж өгөөгүй тул хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна. Мөн «адил нөхцөлд тэгш хандах» гэсэн зарчим бүрэн агуулгаа илэрхийлж чадахгүй байна.

**Санал:** «Адил нөхцөлд тэгш хандах» гэсэн зарчмын өмнө «ялгаварлан гадуурхахгүй байх» гэж нэмэх.

- ☑ Захиргааны ерөнхий хуулийн нэг чухал үзэл баримтлал бол захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцох оролцоог баталгаажуулах явдал юм. Энэ хүрээнд захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, захиргааны хэм хэмжээний актын төсөлд болон төлөвлөлтөд санал авах гэсэн хэсгүүдэд иргэд, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгүүдээс санал авах талаар зохицуулжээ. Гэсэн хэдий ч оролцоог хангасан зохицуулалтыг хооронд нь адилтган томъёолох шаардлага тулгарч байна. Тухайлбал, санал авах арга хэлбэр захиргааны шийдвэрт «сонсох ажиллагаа», захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт «хэлэлцүүлэг» гэж ялгаатай томъёологджээ. Төлөвлөлтийн явцад «сонсох ажиллагаа», «хэлэлцүүлэг» хоёр нь зэрэгцэн орж ирсэн нь бүр ч ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Түүнчлэн хуулийн төсөлд туссанаар захиргааны байгууллагад захиргааны шийдвэр гаргахдаа сонсох ажиллагааг хийхгүй байх өргөн эрх мэдэл олгогджээ. Мөн сонсох ажиллагааг хийгээгүй тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагавар, иргэний шаардах эрхийг орхигдуулсан байна. Үүний зэрэгцээ тусгай хэрэгцээтэй бүлгүүд тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийг хүртээмжтэй хүргэх, оролцох боломжоор хангах зэрэг зохицуулалт тусаагүй байна. Саналыг нь тусгасан эсэхийг эргэж мэдэгдэх үүрэг «төлөвлөлт» дээр л гарч ирж байна. Иргэний оролцох боломжийг «захиргааны шийдвэр», «захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр» болон «төлөвлөлт»-ийн явцад хэрхэн тусгасныг Хүснэгт 1-д харьцуулж үзүүлэв.
- ☑ Мөн оролцоог хангаагүй тухай иргэдийн гомдох боломж тусгагдаагүй, сонсох болон санал авах ажиллагааг явуулсан болохоо нотлох үүргийг захиргааны байгууллагад хүлээлгэлгүй орхижээ. Шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах үүрэг хүлээсэн субъектийг тодорхойлоогүй, эсхүл хоорондоо зөрчилдөх зэрэг түгээмэл зөрчил байна. Тухайлбал, захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад санал авах ажлыг ямар субъект хийхийг тодорхойлоогүй. Харин төлөвлөгөөнд санал

авах сонсох ажиллагааг шийдвэр гаргах захиргааны байгууллага хариуцна (73.1) гэж тодорхойлоод «сонсох ажиллагаа болон хэлэлцүүлэг явуулсан захиргааны байгууллага нь ... саналыг шийдвэр гаргах захиргааны байгууллагад хүргүүлнэ» (75.3) гэж зохицуулсан нь зөрчилтэй байна. Үүнийг шууд утгаар нь авч үзвэл сонсох ажиллагаа зохион байгуулчихаад гарсан саналаа өөртөө хүргүүлэхээр болжээ.

- ☑ Хуулийн төсөлд «төлөвлөлт» гэсэн шинэ зохицуулалт орж ирсэн нь оршин суугчдын оролцоогүйгээр өмнөөс нь төлөвлөдөг, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг арилгах сайн талтай ч энэ бүлэг хангалттай сайн боловсруулагдаагүйн улмаас өөр хоорондоо зөрчилтэй, ойлгомжгүй, тодорхойгүй зүйл заалт нэлээд байна.
- ☑ Иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол, нийтийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

**Санал:** Захиргааны шийдвэр, шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлсний улмаас иргэнд учирсан хохирол болон хохирол, нөхөх олговрын хэмжээний талаарх маргааныг иргэний шүүхээр шийдвэрлүүлэхээр (105.4, 110.2, 112,4) зохицуулсныг захиргааны хэргийн шүүхийн журмаар нэхэмжлэхээр өөрчлөн найруулах. Үүний дүнд цаг хугацаа хэмнэх, оролцогчдын тэгш байдлыг хангах боломж бүрдэнэ. Мөн хуулийн төслийн 108-р зүйлд «иргэн хохирлоо арилгуулахдаа ТББ-аар төлөөлүүлэн нэхэмжлэх эрхтэй» гэсэн шинэ заалт нэмэх.

- ☑ Хуулийн төслийн зарим зохицуулалт бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Тухайлбал, 9.1, 9.2 заалт нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14-р зүйлд заасан «төрийн албан тушаалтан төрийн байгууллагыг төлөөлж болохгүй хориглолт»-ыг зөрчиж «хойшлуулшгүй» тохиолдолд төлөөлж болохоор заажээ.

*Хүснэгт 1. Захиргааны шийдвэр, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах, төлөвлөлт хийхэд иргэдийн оролцоог баталгаажуулсан нь (харьцуулсан хүснэгт)*

| № | Харьцуулах үзүүлэлт                       | Захиргааны шийдвэр   | Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр                                       | Төлөвлөлт  |
|---|---|--|---|--|
| 1 | Оролцоог хариуцах байгууллага             | Сонсох ажиллагааг хэн хариуцан хийхийг тодорхой заагаагүй. | Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага -61.1                  | Шийдвэр гаргах захиргааны байгууллага, сонсох ажиллагаа явуулсан захиргааны байгууллага - 73.1, 75.1 |
| 2 | Сонсох ажиллагааг зайлшгүй явуулах нөхцөл | Зайлшгүй хийх нөхцөл тусгагдаагүй.                         | Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлах - 62.2 | Төлөвлөлт - 76.1, бусдын эрх, ашиг сонирхлыг хөндсөн өөрчлөлтийг төлөвлөгөөнд оруулах- 79            |

|   |  |   |   |   |
|---|--|---|---|---|
| 3 | Сонсох, санал авах ажиллагааг явуулахгүй байх нөхцөл       | Хийх боломжгүй, шаардлагагүй гэж үзэх, нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, гарцаагүй байдал, хойшлуулшгүй ажиллагааны улмаас, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн, техник хэрэгслийн тусламжтай захиргааны шийдвэр гаргах бол, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, нууцад хамаарах бол - 29.1 | Гамшгаас хамгаалах, гамшиг тохиолдох үед - 63.1   | Нийтийн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөөгүй, эсхүл тухайн этгээдэд өмнө нь танилцуулагдаж байсан бол - 77.1  |
| 4 | Сонсох ажиллагаанд оролцох этгээд                          | Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй - 27.1, эсхүл хөндөгдөж буй этгээд - 28.1  | Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх бүлэг - 62.2, эрдэмтэн, судлаач, шинжээч, тодорхой нутаг дэвсгэр, төрийн болон ТББ хүрээнд - 62.3 | Төлөвлөлт хийгдэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ЗД - 73.3, эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй этгээд - 28.1   |
| 5 | Саналыг нь заавал авах этгээд                              | Тусаагүй  | Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх бүлэг - 62.2  | Төлөвлөлт хийгдэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ЗД - 73.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй этгээд - 28.1  |
| 6 | Сонсох, санал авах ажиллагааг мэдэгдэх арга хэлбэр         | Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд 20 хүртэл байвал өөрт нь шууд, 20-иос дээш бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, бусад тохирох арга хэрэгсэл ашиглан - 28.2   | Цахим хуудас, мэдээллийн самбарт төслийг байрлуулан - 62.1  | Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд 20 хүртэл байвал өөрт нь шууд, 20-иос дээш бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, бусад тохирох арга хэрэгсэл ашиглан - 28.2                         |
| 7 | Санал авах, сонсох ажиллагааны тухай мэдэгдэлд тусгах зүйл | Сонсох ажиллагааг явуулах журам, цаг, байр, дараалал, ЗШ гаргах эрх олгосон хуулийн заалт, ЗШ гаргах гэж буй асуудлын талаарх мэдээлэл, шийдвэр гаргах үндэслэл болсон хууль, эрх зүйн актын заалт - 28.4   | Байхгүй   | Сонсох ажиллагааг явуулах журам, цаг, байр, дараалал, ЗШ гаргах эрх олгосон хуулийн заалт, ЗШ гаргах гэж буй асуудлын талаарх мэдээлэл, шийдвэр гаргах үндэслэл болсон хууль, эрх зүйн актын заалт - 28.4 |

|    |  |  |   |   |
|----|--|--|---|---|
| 8  | <b>Санал авах хэлбэр</b>                             | Уулзалт, бичгээр, биечлэн уулзах, утас, цахим, төлөөлөгчөөр дамжуулан - 28.3<br>- Бусад хэлбэрийг нээлттэй орхиогүй  | Уулзалт, ярилцлага, өдөр тутмын хэвлэлд шийдвэрийн төслийг нийтэлж, албан ёсны цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр, бусад - 62.4   | Уулзалт, бичгээр, биечлэн уулзах, утас, цахим, төлөөлөгчөөр дамжуулан - 28.3<br>- Бусад хэлбэрийг нээлттэй орхиогүй   |
| 9  | <b>Сонсох, санал авах ажиллагааг явуулах хугацаа</b> | Оролцогчдын оролцоо, тайлбар санал гаргах боломжийг хангахуйц байна - 28.5   | 30-аас доошгүй хоног байрлуулж санал авна - 62.1  | Төлөвлөгөөг хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор - 73.3, Хугацааг сунгаж болно - 73.4, 74.1 - хугацаа тодорхойгүй, хугацааг өөрөөр тогтоох, эсхүл сунгаж болно - 74.2   |
| 10 | <b>Саналд хариу тайлбар хийх, мэдэгдэх</b>           | Саналыг заавал тусгах шаардлагагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд саналыг тусгаагүй талаар тайлбарлах үүрэгтэй - 28.6 Тайлбарыг хэнд гаргах нь тодорхойгүй, санал гаргасан этгээдэд мэдээлэх үүргийг хүлээлгээгүй. | Гарсан саналыг актын төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ - 62.5, Хууль зүйн асуудал хариуцсан нэгжээр хянуулна - 62.6, ХЗЯ-д хүргүүлнэ - 66.1.1 санал гаргасан этгээдэд мэдэгдэх талаар тусаагүй. | Эсрэг саналыг төлөвлөгөөнд тусгаагүй тохиолдолд тайлбарлах үүрэгтэй - 74.3, эсрэг саналыг шийдвэр гаргах захиргааны байгууллагад хүргүүлэх - 75.3, эсрэг саналыг хүлээн аваагүй талаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэх үүрэгтэй - 76.4 |
| 11 | <b>Оролцоог хангаагүй тохиолдолд</b>                 | Ямар нэг зохицуулалт байхгүй.  | ХЗЯ бүрдэл дутуу хэмээн буцаах үндэслэл болно - 66.2  | Шийдвэр гаргах захиргааны байгууллага сонсох ажиллагааг явуулсны дараа саналыг эцэслэн шийдвэрлэнэ - 76.1   |

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**  
ННФ-ын Засаглалын  
хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)